

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/091/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Улаангом хот
2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Аудитор: Р.Аюуш
Утас: 70453799, Цахим хаяг: Ayushr@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн үзүүлэтүүд.....	13
4. Аудитын тайлан.....	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ч.ЭНХБАЯР
ТАНАА

2026.02.24 № УВА-2026/091/НА-СТА-ТЧЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050245

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
35	БАРАА МАТЕРИАЛ	1,743,700.00	
354	Хангамжийн материал	1,743,700.00	
3542	Аж ахуйн материал	435,800.00	
3547	Бусад хангамжийн материал	1,307,900.00	
36	НӨӨЦИЙН БАРАА		
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,743,700.00	
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	59,710,726.39	606,341,605.96
392	Биет хөрөнгө	59,710,726.39	596,112,439.26
39203	Авто-тээврийн хэрэгсэл	139,000,000.00	340,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-139,000,000.00	-10,625,000.01
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	157,670,695.45	292,274,700.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-102,667,209.76	-72,671,435.17
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,971,890.00	67,986,390.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-29,742,243.72	-23,719,643.34
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,568,000.00	4,535,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,414,805.58	-1,991,972.22
39217	Ном	324,400.00	324,400.00
393	Биет бус хөрөнгө		10,229,166.70
39301	Программ хангамж	550,000.00	12,050,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-1,820,833.30
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	59,710,726.39	606,341,605.96
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	61,454,426.39	606,341,605.96
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		79,383,500.00
413	Өглөг		79,383,500.00
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг		6,988,200.00
4136	Бусад өглөг		72,395,300.00
41361	Байгууллагад төлөх өглөг		59,134,300.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		13,261,000.00
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		79,383,500.00
51	Засгийн газрын хувь оролцоо	61,454,426.39	526,958,105.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	174,528,903.80	174,528,903.80
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	174,528,903.80	174,528,903.80
512	Хуримтлагдсан үр дүн	-113,074,477.41	352,429,202.16
5121	Өмнөх үеийн үр дүн	-113,074,477.41	-113,074,477.41
5122	Тайлант үеийн үр дүн		465,503,679.57
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	61,454,426.39	526,958,105.96
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	61,454,426.39	606,341,605.96

2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,300,158,700.00	2,115,218,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	89,000,000.00	141,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	89,000,000.00	141,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,211,158,700.00	1,974,218,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,211,158,700.00	1,974,218,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		340,455,000.00
120	Нийтлэг татварын бус орлого		340,455,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		340,000,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		455,000.00
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,300,158,700.00	2,455,673,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,299,581,882.67	1,989,234,649.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,118,299,900.41	1,657,203,608.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	479,304,076.66	703,212,524.96
210101	Үндсэн цалин	257,993,718.41	329,999,772.07
210102	Нэмэгдэл	161,950,068.25	323,569,727.14
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,970,000.00	27,084,546.84
210104	Урамшуулал	37,390,290.00	22,558,480.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,879,296.64	88,031,112.36
210201	Тэтгэврийн даатгал	40,836,886.54	59,907,703.65
210202	Тэтгэмжийн даатгал	4,261,325.90	7,047,965.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,875,114.81	3,523,982.44
210204	Ажилгүйдлийн даатгал	2,181,193.87	3,510,292.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,724,775.52	14,041,167.95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,500,000.00	11,250,000.00
210304	Байрны түрээс	24,500,000.00	11,250,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	164,397,273.44	267,390,563.40
210401	Бичиг хэрэг	46,870,600.00	52,912,980.00
210402	Тээвэр, шатахуун	94,369,665.00	102,349,984.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,797,928.44	37,342,855.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,359,080.00	72,596,044.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		2,188,700.00
2105	Нормативт зардал		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,219,200.00	24,687,825.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	620,000.00	
210604	Урсгал засвар	21,599,200.00	24,687,825.00
2107	Томилолт, зочны зардал	46,800,900.00	113,293,150.00
210701	Гадаад албан томилолт		12,441,600.00
210702	Дотоод албан томилолт	46,800,900.00	100,851,550.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,090,541.00	31,627,802.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,158,441.00	26,450,796.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,800,000.00	4,560,906.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	155,100.00	162,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,523,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	294,108,612.67	417,710,631.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	201,394,230.00	200,274,644.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	75,959,200.00	173,409,938.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,755,182.67	44,026,049.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	181,281,982.26	332,031,040.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	91,569,443.83	52,398,360.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		21,213,360.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,214,728.83	
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,854,715.00	9,731,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	42,500,000.00	21,454,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	89,712,538.43	279,632,680.28
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	89,712,538.43	279,632,680.28
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,299,581,882.67	1,989,234,649.06
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	576,817.33	466,438,350.94
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		934,671.37
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө		934,671.37
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		-934,671.37
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	576,817.33	465,503,679.57

2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,300,158,700.00	2,115,218,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,300,158,700.00	2,115,218,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	89,000,000.00	141,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	89,000,000.00	141,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,211,158,700.00	1,974,218,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,211,158,700.00	1,974,218,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,300,158,700.00	1,872,626,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,300,158,700.00	1,872,626,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,118,876,717.74	1,539,885,359.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	479,304,076.66	703,212,526.05
210101	Үндсэн цалин	256,314,345.67	306,701,080.00
210102	Нэмэгдэл	163,629,440.99	341,412,465.47
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,970,000.00	26,853,546.84
210104	Урамшуулал	37,390,290.00	28,245,433.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,879,296.64	88,031,111.27
210201	Тэтгэврийн даатгал	40,836,886.54	59,907,703.65
210202	Тэтгэмжийн даатгал	4,757,627.15	7,047,965.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,378,813.56	3,523,982.44
210204	Ажилгүйдлийн даатгал	2,181,193.87	3,510,292.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,724,775.52	14,041,167.95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,000,000.00	11,250,000.00

/төгрөгөөр/

210304	Байрны түрээс	26,000,000.00	11,250,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	161,447,173.44	174,466,581.40
210401	Бичиг хэрэг	44,969,250.00	38,328,920.00
210402	Тээвэр, шатахуун	94,369,665.00	88,631,834.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,797,928.44	25,197,855.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,310,330.00	22,307,972.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,788,200.00	47,030,825.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,189,000.00	-
210604	Урсгал засвар	21,599,200.00	47,030,825.00
2107	Томилолт, зочны зардал	46,800,900.00	100,851,550.00
210702	Дотоод албан томилолт	46,800,900.00	100,851,550.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,280,541.00	28,072,402.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,348,441.00	27,176,296.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,800,000.00	163,506.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	155,100.00	158,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,523,000.00	120,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	277,376,530.00	386,970,364.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	197,607,330.00	205,025,994.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	79,769,200.00	181,944,370.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	181,281,982.26	332,741,040.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	91,569,443.83	53,108,360.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	21,213,360.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,214,728.83	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,854,715.00	9,731,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	42,500,000.00	22,164,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	89,712,538.43	279,632,680.28
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	89,712,538.43	279,632,680.28
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	242,591,600.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	242,591,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	242,591,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	242,591,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	242,591,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	(242,591,600.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	

2.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	174,528,903.80	-	(113,651,294.74)		60,877,609.06
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	174,528,903.80	-	(113,651,294.74)	-	60,877,609.06
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	576,817.33		576,817.33
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	174,528,903.80	-	(113,074,477.41)	-	61,454,426.39
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	174,528,903.80	-	(113,074,477.41)	-	61,454,426.39
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	174,528,903.80	-	(113,074,477.41)	-	61,454,426.39
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	465,503,679.57		465,503,679.57
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	174,528,903.80	-	352,429,202.16	-	526,958,105.96

2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,974,128,000.00	1,974,218,000.00	-90,000.00	100%
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,974,128,000.00	1,974,218,000.00	-90,000.00	100%
132001	Орон нутгийн төсвөөс	1,974,128,000.00	1,974,218,000.00	-90,000.00	100%
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,974,128,000.00	1,974,218,000.00	-90,000.00	100%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,974,128,000.00	1,694,585,319.72	279,542,680.28	86%

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,919,383,600.00	1,761,576,959.72	157,806,640.28	92%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	710,800,300.00	703,212,526.05	7,587,773.95	99%
210101	Үндсэн цалин	304,876,700.00	306,701,080.00	-1,824,380.00	101%
210102	Нэмэгдэл	346,946,200.00	341,412,465.47	5,533,734.53	98%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,600,000.00	26,853,546.84	-11,253,546.84	172%
210104	Урамшуулал	43,377,400.00	28,245,433.74	15,131,966.26	65%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,850,000.00	88,031,111.27	818,888.73	99%
210201	Тэтгэврийн даатгал	60,418,000.00	59,907,703.65	510,296.35	99%
210202	Тэтгэмжийн даатгал	7,108,000.00	7,047,965.23	60,034.77	99%
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,554,000.00	3,523,982.44	30,017.56	99%
210204	Ажилгүйдлийн даатгал	3,554,000.00	3,510,292.00	43,708.00	99%
210205	Эрүүл мэндийн даатгал	14,216,000.00	14,041,167.95	174,832.05	99%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,250,000.00	11,250,000.00		100%
210304	Байрны түрээс	11,250,000.00	11,250,000.00		100%
2104	Хангамж, бараа материалын зардал	197,017,600.00	174,466,581.40	22,551,018.60	89%
210401	Бичиг хэрэг	45,020,000.00	38,328,920.00	6,691,080.00	85%
210402	Тээвэр, шатахуун	92,750,000.00	88,631,834.40	4,118,165.60	96%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	38,002,100.00	25,197,855.00	12,804,245.00	66%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,245,500.00	22,307,972.00	-1,062,472.00	105%
2105	Нормативт зардал				
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	270,007,300.00	273,172,425.00	-3,165,125.00	101%
210601	Багаж, техник, хэрэгсэл	221,800,000.00	177,526,700.00	44,273,300.00	80%
210602	Тавилга	50,000.00	48,614,900.00	-48,564,900.00	
210604	Урсгал засвар	48,157,300.00	47,030,825.00	1,126,475.00	98%
2107	Томилолт, зочны зардал	101,000,000.00	100,851,550.00	148,450.00	100%
210702	Дотоод албан томилолт	101,000,000.00	100,851,550.00	148,450.00	100%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	66,446,000.00	30,572,402.00	35,873,598.00	46%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	56,300,000.00	27,176,296.00	29,123,704.00	48%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00		100%
210803	Даатгалын үйлчилгээ	2,500,000.00	163,506.00	2,336,494.00	7%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	160,000.00	158,600.00	1,400.00	99%
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	22,000.00	22,000.00	50%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,000,000.00	2,620,000.00	4,380,000.00	37%
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,000.00		10,000.00	0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	474,012,400.00	380,020,364.00	93,992,036.00	80%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	229,022,400.00	198,075,994.00	30,946,406.00	86%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	244,990,000.00	181,944,370.00	63,045,630.00	74%

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,744,400.00	-66,991,640.00	121,736,040.00	-122%
2132	Бусад урсгал шилжүүлэг	54,744,400.00	53,108,360.00	1,636,040.00	97%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,213,400.00	21,213,360.00	40	100%
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,731,000.00	9,731,000.00		100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,800,000.00	22,164,000.00	1,636,000.00	93%
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		-120,100,000.00	120,100,000.00	
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		-120,100,000.00	120,100,000.00	
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,974,128,000.00	1,974,218,000.00	-90,000.00	100%
3	Төсвийн байгууллага	1	1		100%
5	АЖИЛЛАГСДЫН ТОО	14			
6	Удирдах ажилтан	3	3		100%
7	Гүйцэтгэх ажилтан	9	9		100%
8	Үйлчлэх ажилтан	2	2		100%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	20,900,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	20,900,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,900,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,900,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,900,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	20,900,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,900,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,900,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь иргэдийн оролцоог хангах, нээлттэй, ил тод үйл ажиллагаанд тулгуурлан Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлж хүний хөгжил, амьдралын чанарыг хангахуйц бодлого зорилтыг тодорхойлон аймгийн эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангана гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2024 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 544,887.2 мянган төгрөгөөр буюу 90.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	1,743.7		-1,743.7
Үндсэн хөрөнгө	59,710.7	606,341.6	546,630.9
Нийт хөрөнгө	61,454.4	606,341.6	544,887.2
Өр төлбөр	0.0	79,383.5	79,383.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	61,454.4	526,958.1	465,503.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	61,454.4	606,341.6	544,887.2

Бараа материалын данс 1,743.7 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн материал, бусад хангамжийн материалын эхний үлдэгдлийг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 606,341.6 мянган төгрөг болж 546,630.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 191,476.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 48,614.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 11,500.0 мянган төгрөгийн программ хангамж хөрөнгө худалдан авч, 340,000.0 мянган төгрөгийн машин үнэ төлбөргүй хүлээн авч, тайлант онд 44,026.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцож, 207,506.1 мянган төгрөгийн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 79,383.5 мянган төгрөг болж өссөн нь дансны зарлагын гүйлгээ хийх эрхийг хязгаарласнаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 526,958.1 мянган төгрөг болж 465,503.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,438,207.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,438,207.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөсөн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 441,020.7 мянган төгрөгөөр өсгөж, орон нутгийн төсвөөс 1,879,228.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 94,900.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,974,128.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,974,128.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,814,685.2 мянган төгрөг буюу 91.9 хувьтай байна. батлагдсан төсвөөс 279,632.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал /80101/	1,496,761.2	1,384,649.2	112,112.0	92.5%

2	Мэдээлэл сурталчилгааны зардал /80205/	1,000.0	1,000.0	0.0	100.0%
3	Зөвлөл хороод комиссын гишүүд /80224/	17,600.0	13,199.3	13,511.0	49.4%
4	Биеийн тамир уралдаан тэмцээн /80305/	15,010.0	13,160.0	1,850.0	87.7%
5	Шүүхийн шийдвэрийн дагуу олгох /80307/	24,640.1	24,640.1	0.0	100.0%
6	Ажил олгогчоос олгох тэтгэмж /80802/	33,531.0	31,895.0	1,636.0	95.1%
7	Сонгуулийн үр дүнгээс /80815/	21,213.4	21,213.4	0.0	100.0%
8	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх /82201/	139,372.3	115,329.0	24,043.2	82.7%
9	Гамшгаас урьдчилан сэргийлэх /83201/	50,000.0	44,946.8	13,582.4	69.6%
10	Ангилалдаагүй бусад зориулалт /83201/	175,000.0	164,652.4	10,347.6	94.0%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5, 2.6-д харуулав.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

Программын судалгааг хүснэгтээр харуулахад дараах байдалтай байна.

/мянган төгрөгөөр/				
Д/Д	Программ, лиценз нийлүүлсэн байгууллагын нэр	Санхүүгийн тайланд бүртгэлтэй эсэх /тийм, үгүй/	Зориулалт	Тайланд онд гэрээний дагуу төлсөн төлбөр
1	Си Ти Эс	тийм	Санхүү	2,500.0
2	Мармин тек ххк	тийм	Төлөөлөгчдийн санал хураалт, ирц, мэдээлэл дамжуулах	9,900.0
Нийт дүн				11,500.0

Унаа, хоол, сургалт семинарын орон тооны судалгааг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөг/					
№	Үзүүлэлт	Төсөвлөсөн	Гүйцэтгэл	Зөрүү	Тайлбар
1	Унаа, хоолны зардал	15,600.0	26,853.5	-11,253.5	АИТХ-ын дотоод журмын 2022 оны 11 дүгээр сарын 01-ны А/110 дугаар тушаал
2	Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардал	175,000.0	131,044.0	43,956.0	Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусадсаны дагуу ОХУ-ын Бүгд Найрамдах Тува улсад гэрээ хэлэлцээ хийхээр айлчлах зардал, Баруун бүсийн сургалт зөвлөгөөн Завхан аймаг болон Ховд аймагт зохион байгуулагдсан.
3	Гадаад томилолт, арга хэмжээ	0.00	12,441.6	-12,441.6	ОХУ-ын Тува улсад албан ёсны хамтын ажиллагааны хүрээнд уулзалт хэлэлцүүлэгт оролцсон
4	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	24,640.1	24,640.1	0.00	2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 124/ШШ2025/0015 дугаар шүүхийн захирамжийн дагуу хохирол барагдуулсан.

5	Орон тоо	14	14	0.00	Бүтэц орон шинэчлэн баталсан байна.
7	Хэвлэл мэдээлэл	5,800.0	5,800.0	0.00	Орон нутгийн 2 телевизтэй хамтран ажиллах гэрээний төлбөр.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 141,000.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс зардалд үндсэн үйл ажиллагаанд 20,900.0 мянган төгрөгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд зарцуулсан зарцуулж, 120,100.0 мянган төгрөгийн буцаан төвлөрүүлсэн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тайлант онд 63,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй түлш, шатах тослох материал нийлүүлэх нээлттэй тендер, 127,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэх нээлттэй тендерийг тус тус зохион байгуулсан байна.

Харин аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь төсвийн хөрөнгөөр 53,086.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 48,614.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авахдаа тендер зарлахгүйгээр төсөвт өртгийг хувааж, шууд худалдан авалт хийсэн зөрчил илэрсэнд албан шаардлага өглөө.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Аюуш гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,299,581.9 мянган төгрөгийн 1 хувиар буюу 12,995.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,989,234.6 мянган төгрөгийн 1 хувиар буюу 19,892.3 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 15,913.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсөв захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа үйлчилгээний бусад зардлаас аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албан хаагчид, Хурлын төлөөлөгчдөд 4 хос спорт хувцсыг 13,160.0 мянган төгрөгөөр худалдан авч тараасан нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 39.1.2 дахь заалтад “Албаны эрх мэдлээ хэтрүүлэх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно” гэж заасныг зөрчсөнд цаашид зөрчлийг давтан гаргуулахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахаар зөвлөмж өглөө.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 164, хугацаа хоцроон байршуулсан 5, мэдээлэх хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорил хэрэгжүүллээ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн Б/04 дүгээр захирамжаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийг ажлаас чөлөөлж, 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн Б/05 дугаар захирамжаар Зохион байгуулалт, олон нийттэй харилцах хэлтсийн даргыг Нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилжээ. Мөн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн Б/06 дугаар захирамжаар Зохион байгуулалт, олон нийттэй харилцах хэлтсийн даргыг Нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээс чөлөөлсөн байна.

Зохион байгуулалт, олон нийттэй харилцах хэлтсийн даргын 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн Б/20 дугаар тушаалаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэж байсан ажилтныг Мэдээлэл технологи, цахим хуудас хариуцсан мэргэжилтнээр шилжүүлэн томилсон байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн Б/07 дугаар захирамжаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Мэдээлэл технологи, цахим хуудас хариуцсан мэргэжилтэнг томилон ажиллуулсан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй бөгөөд зөвлөмж өгөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын шийдвэрээр нягтлан бодох бүртгэлийн ажилтанд мэргэшсэн эрхийн нэмэгдэл олгож болно” гэж заасныг үндэслэн Монголын мэргэшсэн нягтлан бодогчийн мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 15 хувиар тооцож 3,796.7 мянган төгрөгийг олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2 дахь хэсэгт “Захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон төрийн алба хаасан хугацааны, цолны, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс бүрдэнэ” гэж заасантай зөрчилдөж байгаа тул харьяалах дээд шатны байгууллагад санал хүргүүлэхээр болов.
2. Аймгийн Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/14 дүгээр тушаалаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, орон тоог шинэчлэн батлахдаа 15 орон тоотойгоор баталсан байна. Мөн Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 376 дугаар “Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны бүтэц, аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны орон тооны хязгаарыг тогтоох тухай” тогтоолын 1-д “Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн тооноос хамааруулан Говьсүмбэр

аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албыг 8, Архангай, Баян-Өлгий, Булган, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Дундговь, Орхон, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Хэнтий аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албыг 10, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Өвөрхангай, Төв, Увс, Ховд, Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албыг 12 хүртэл орон тоотой байхаар тус тус тогтоосугай” гэж заасныг үндэслэн аймгийн хурлын даргын туслах, хэвлэл мэдээллийн ажилтан гэсэн 2 орон тоог баталсан байна. Засгийн газрын 376 дугаар тогтоолоор баталсан орон тоог хэтрүүлсэн асуудлыг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 191,965.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 18,264.0 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгч, 101,701.6 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага өглөө.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь төсвийн хөрөнгөөр 53,086.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 48,614.9 мянган төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авахдаа тендер зарлахгүйгээр төсөвт өртгийг хувааж, шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлд тендер зохион байгуулалт, 10.3 дахь хэсэгт “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно”, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20.0 сая төгрөг байна” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Засгийн газрын “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” тогтоолыг хэрэгжүүлээгүй зөрчлийг давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өглөө.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бүтэц, орон тоотой холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Байгууллагын батлагдсан бүтэц, орон тоонд байхгүй нярвын ажлыг хавсруулж 5,104.0 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй нь Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэж заасныг дагаж мөрдөх.

2. Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой

2.1. Илрүүлэлт:

Бараа үйлчилгээний бусад зардлаас аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албан хаагчид, Хурлын төлөөлөгчдөд 4 хос спорт хувцсыг 13,160.0 мянган төгрөгөөр худалдан авч тараасан байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 39.1.2 дахь заалтад “Албаны эрх мэдлээ хэтрүүлэх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй нь Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно” гэж заасныг дагаж мөрдөх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор ирүүлж, биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн дотор, албан шаардлагын биелэлтийг 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бүтэц орон тоонд байхгүй хавсарсан олгосон байна.	1	5,104.0					1	5,104.0				
Дүн	1	5,104.0					1	5,104.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
Дүн							
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
Тендер зарлахгүйгээр төсөвт өртгийг хувааж, шууд худалдан авалт хийсэн.	1	101,701.6			1	101,701.6	
4 хос спорт хувцсыг худалдан авч тараасан байна.	1	13,160.0					13,160.0
Дүн	2	114,861.6			1	101,701.6	13,160.0
Нийт дүн	2	114,861.6			1	101,701.6	13,160.0

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



2026 оны 02 дугаар сарын 24-ний өдөр

